

Бие даан ажиллах бодлого, дасгал

Бодлого 1. X санамсаргүй хэмжигдэхүүний хувьд $E(X) = 10, E(X^2) = 136$ бол стандарт хазайлтыг тооц.

/ Хариу $\sigma = 6$ /

Бодлого 2. X санамсаргүй хэмжигдэхүүний хувьд $E(X) = 12, E(X^2) = 169$ бол $Var(2X - 3)$ –ийг ол.

/ Хариу 100 /

Бодлого 3. X санамсаргүй хэмжигдэхүүний хувьд $E(X^2) = 224, Var(4X) = 1280$ бол $E(5X + 3)$ –ийг ол.

/ Хариу 63 /

Бодлого 4. X санамсаргүй хэмжигдэхүүний тархалтын хууль өгөгдөв.

X	-1	2	3	k
$P(x_i)$	0.2	0.3	0.3	0.2

Уг санамсаргүй хэмжигдэхүүний математик дундаж нь 2.5 бол стандарт хазайлтыг ол.

/ Хариу 2.25 /

Бодлого 5. Хайрцагт байсан 8 бүтээгдэхүүний 3 нь гологдол бүтээгдэхүүн байв. Нэг бүтээгдэхүүн таамгаар аваад гологдол байвал дахиад нэгийг авч шалгах замаар гологдол биш бүтээгдэхүүн гарч иртэл туршилтыг үргэлжлүүлнэ. Бүтээгдэхүүн сугалах тооны математик дунджийг ол.

/ Хариу 1.5 /

Бодлого 7. Нэг хүн 2 мөнгө хаях тоглоомонд оролцжээ. Хоёр сүлд тусвал 1000 төгрөг нэг сүлд тусвал 500 төгрөг хожно. Харин нэг ч сүлд тусгаж чадахгүй бол 3000 төгрөг төлнө. X ээр хожлын хэмжээг тэмдэглэвэл хожлын математик дунджийг ол.

/ Хариу –150 /

Бодлого 8. Хоёр шоо хаяхад туссан нүхний минимум утгыг авдаг X санамсаргүй хэмжигдэхүүний тархалтын хуулийг бичиж, математик дунджийг ол.

/ Хариу 4.47 /

Бодлого 9. X_1, X_2, X_3 санамсаргүй хэмжигдэхүүнүүдийн математик дунджууд харгалзан 10, 15, 15 бол $2X_1 + 3X_2 + 4X_3$ санамсаргүй хэмжигдэхүүний математик дунджийг ол.

/ Хариу 125 /

Бодлого 10. Мөнгийг 3 удаа хаяхад тоо буух тоог X гэе. X -ийн тархалтын хуулийг бичиж вариацийг тооц.

/ **Хариу** 0.75/

Бодлого 11. 1-ээс 12 хүртэлх натурал тоонуудын хуваагчийн тоог X гэе. X -ийн тархалтын хуулийг бичиж, математик дундаж болон стандарт хазайлтыг тооц.

/ **Хариу** 1.32/

Бодлого 12. Мөнгийг нэг сүлд эсвэл тоо 3 удаа тусах хүртэл хаяна. Мөнгө хаях тооны математик дундаж, вариацийг тооц.

/ **Хариу** $\frac{11}{16}$ /